

Сурлагын хоцрогдлыг арилгах төлөвлөгөө
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурлагын хоцрогдлыг арилгахын төлөө -

Бичил төсөл 2 (Зорилтот бүлэг: Сонсголын бэрхшээлтэй хүүхэд)

1. Төслийн үндэслэл

Монгол Улс шинэ хэлбэрийн коронавирусын халдвараас хамгаалах зорилгоор, 2020 оны 1 дүгээр сарын сүүлээс эхлэн цэцэрлэг, сургуулийн танхимын сургалтын үйл ажиллагааг өнөөг хүртэл зогсоосон. Төсөл болон цахим хичээлийг зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулж байгаа хэдий ч, хүүхдүүдийн суралцахуйд ноцтой хоцрогдол үүсэх болсон.

Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд онцлог хэрэгцээ шаардлагадаа нийцсэн боловсролын үйлчилгээг авахад хүндрэлтэй байгаа бөгөөд сурч боловсрох эрхээ хангалттай хэмжээнд эдлэх боломжгүй нөхцөл байдалд байна.

Боловсролын хүрээлэн болон Японы Хүүхдийг ивээх сангаас зохион байгуулсан судалгаагаар, тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн сурч боловсрох хэрэгцээ шаардлагатай зэрэгцэн, асран хамгаалагчид ч хүүхдийнхээ суралцахуйг дэмжих арга, аргачлалыг эрэлхийлэх болсон нь тодорхой болжээ.

Энэхүү нөхцөл байдлыг үндэс болгон, START төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйд дэмжлэг үзүүлэх зорилгоор бичил төсөл хэрэгжүүлэхээр тогтсон болно.

2. Энэхүү бичил төслийн зорилтот бүлэг ба зорилго

Сонсголын бэрхшээлтэй хүүхэд нь 2, 3 насандаа дохионы хэлний суурьтай болох ёстой боловч ихэнх асран хамгаалагчид дохионы хэл мэддэггүй тул гэрийн нөхцөлд дохионы хэл сурахад хүндрэлтэй байдаг. Нийслэлд сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролоор дагнасан цэцэрлэг, сургууль, байгууллага байдаг ч орон нутагт бараг байхгүй, хүний нөөцийн хомсдолтой байдал зэргээс шалтгаалж, хүүхдүүд харилцааны аргад суралцаж амжилгүй сургуулийн насанд хүрэх нь элбэг байна. Цар тахлын энэ цаг үед сургууль, цэцэрлэг ажиллахгүй байгаа тул хүүхдүүд гэртээ байна.

Тиймээс энэхүү бичил төслийн хүрээнд, сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид, цэцэрлэг, сургуулийн багш нарт дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох цахим сургалтын материал боловсруулж түгээх ажлыг зохион байгуулна.

3. Санхүүжилт, хугацаа, шалгаруулах төслийн тоо

START төслөөс бичил төслийг санхүүжүүлэх дүн болон хэрэгжүүлэх хугацаа, сонгон шалгаруулах төслийн тоог доор үзүүлэв.

- Санхүүжилтийн дээд хэмжээ: 20,000,000 төгрөг хүртэл
- Хэрэгжүүлэх хугацаа: 2021 оны 10 дугаар сарын 1-нээс 2022 оны 5 дугаар сарын 31
- Сонгон шалгаруулах төслийн тоо: 1 төсөл

4. Зорилтот байгууллага

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаар хангалттай мэдлэг, туршлага бүхий байгууллага.

5. Эцсийн бүтээгдэхүүний үзүүлэлт

- (1) Эцэг эх, асран хамгаалагчид болон багш нарт зориулсан цахим сургалтын хөтөлбөр (киррикулим)

Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах эцэг эх, асран хамгаалагчид болон багш нарын эзэмшвэл зохих дохионы хэл сурах цахим сургалтын хөтөлбөр боловсруулна. Ингэхдээ дараах гурван зүйлд анхаарна.

- Толь бичиг шиг дараалсан олон үг оруулахгүйгээр, амьдралын янз бүрийн нөхцөл байдалд бусадтай харилцах боломжтой дохионы хэлийг заах.
- Хөтөлбөрт 1,2 дугаар ангийн сонсголын бэрхшээлтэй хүүхдэд эх хэл болон математикийн үндсэн мэдлэг, чадварыг эзэмшүүлэх арга зүйг тусгах.
- Боловсруулсан хөтөлбөр, цахим сургалтын материалыг сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш, эцэг эх, асран хамгаалагчид хэсэгчлэн туршиж, үр дүнг тооцсон байх

(2) Сургалт зохион байгуулах болон дүрс бичлэг бэлтгэх

Дээрх сургалтыг орон нутагт байгаа сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид болон цэцэрлэг, сургуулийн багш нарт зохион байгуулна. Сургалтад хамрагдах хүмүүсийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор дамжуулан санал болгоно. Лекцийн дүрс бичлэгийг бэлтгэх ба шаардлагатай гэсэн хүн хэдийд ч давтан үзэх боломжтой байна.

Энэхүү бичил төслийн хүрээнд боловсруулагдсан гарын авлагын зохиогчийн эрхийг ЖАЙКА болон БШУЯ эзэмшинэ. Хэрэгцээтэй хүн бүрд чөлөөтэй ашиглах боломжийг олгох үүднээс БШУЯ-ны холбогдох байгууллагуудад ч түгээхээр төлөвлөсөн.

6. Сонгон шалгаруулах нөхцөл

Сонгон шалгаруулах нөхцөлийг доор үзүүлэв.

- Энэхүү бичил төслийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахуйц хангалттай туршлага бий эсэх. (3 оноо)
- Санал болгосон эцсийн бүтээгдэхүүний танилцуулга нь энэхүү бичил төслийн зорилго болон дээрх 5.-д заасан үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх. (4 оноо)
- Эцсийн бүтээгдэхүүнийг заасан хугацаанд хүлээлгэж өгөх боломжтой, үйл ажиллагааны зохистой төлөвлөгөө боловсруулсан эсэх. (3 оноо)
- Зардлын төлөвлөгөөнд бодитой бус төлөвлөсөн зүйл бий эсэх. Хэрэв бодитой бус төлөвлөсөн зүйл илэрсэн тохиолдолд сонгогдохгүй болохыг анхаарна уу.

7. Хүсэлт гаргах арга, хүсэлт хүлээн авах хуваарь

Хүсэлт гаргагч нь хавсаргасан Excel файлыг татаж, дор дурдсан агуулга бүхий 4 маягтын дагуу мэдээллээ боловсруулж Excel болон PDF хэлбэрээр jicastart2@gmail.com хаягаар ирүүлнэ үү.

(1) Хүсэлт гаргагч байгууллагын танилцуулга

(2) Эцсийн бүтээгдэхүүний танилцуулга

Цахим сургалтын хөтөлбөр (төсөл)

Цахим сургалт зохион байгуулах төлөвлөгөө

(3) Үйл ажиллагааны төлөвлөгөө

(4) Зардлын дэлгэрэнгүй

Үүнд дараах зардал хамаарна.

- Боловсон хүчний зардал (Явуулын болон туслах багш орон тоогоор ажиллах тохиолдолд бүтэн цалин, харин төрийн албан хаагч ажиллах тохиолдолд зөвхөн илүү цагийн хөлс нэмэлт урамшуулал олгох боломжтой)
- Тээвэр, унааны зардал (Такси, хот хоорондын автобус, нисэх онгоц зэрэг зөвхөн зарлагын баримт авах боломжтой тээврийн хэрэгсэл ашигласан тохиолдолд)
- Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх зардал (Материалын зардал, дүрс бичлэг зураг авалтын зардал, цаас, бичгийн хэрэгсэл, хэвлэлтийн зардал зэрэг)
- Сургалт зохион байгуулах зардал (Танхим түрээслэх зардал, сургагч багшийн хөлс, эх бичвэрийн хөлс)

Хүсэлт хүлээн авах хуваарийг доор үзүүлэв.

- Нээлттэй зарлах: 2021 оны 8 дугаар сарын 2 (Даваа)
- Цахимаар тайлбар хийх уулзалт: 2021 оны 8 дугаар сарын 5 (Пүрэв), 11:00-13:00
<https://us02web.zoom.us/j/84369089670?pwd=bkxWRHdZd0cxRTgrU2E3SDNBY2F4QT09>
ID: 843 6908 9670
Passcode: 076290
- Асуулт хүлээн авах эцсийн хугацаа: 2021 оны 8 дугаар сарын 6 (Баасан), 17:00 цаг хүртэл
Хариултыг, асуулт хүлээн авч дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор START2 төслийн фейсбүүк хуудсанд нийтлэх болно.
- Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2021 оны 8 дугаар сарын 20 (Баасан), 17:00 цаг хүртэл
- Сонгон шалгаруулалтын үр дүнг зарлах: 2021 оны 9 дүгээр сарын 13 (Даваа)